

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААН – Хуралдааны тойм

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНААР ХЭЛЭЛЦСЭН АСУУДЛЫН ХӨТӨЛБӨР ¹ 02 (ТОЙМ)

Хуралдаан 2010 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 14.30 цагт эхэлж, 16.50 цаг хүртэл Засгийн газрын Х1 байрын 301 тоот өрөөнд болж, нийт 2 цаг 20 минут үргэлжлэв.

1	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	Өмнөговь, Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын сонгон шалгаруулалтын тухай	Өмнөговь, Хөвсгөл аймгуудын ЗДТГ-ын даргын ажлын байрны тодорхойлолтод байгаа шаардлагыг эхлээд эндээ үзэж, тогтоод дараа нь Б.Өнөбаатар гишүүн 2 аймагтайгаа яриад ажлын байрны тодорхойлолтод байгаа чиг үүргүүдийг нь ингэж ингэж өөрчиллөө гэж хэлээд, зарчмын хувьд тэд зөвшөөрвөл дараагийн хуралдаанаар хэлэлцэхгүйгээр зарлая гэж тогтов.
2	Батлан хамгаалах яамны Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтанд нэр дэвшүүлж, дүгнэлт гаргах тухай	БХЯ-ны Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний газрын даргын албан тушаалд Насангийн Бямбадоржийг томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга М.Борбаатарт санал болгох тухай МУ-ын ТАЗ-ийн тогтоол гаргахаар тогтов.
3	"Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын төрийн тусгай албан тушаалд анх орох иргэнээс мэргэшлийн шалгалт авах журам"-ын төслийн тухай	1."Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын төрийн тусгай албан тушаалд анх орох иргэнээс мэргэшлийн шалгалт авах журам"-ыг хавсралтаар батлах, 2.Энэхүү журмыг чанд мөрдөж ажиллахыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дэргэдэх ТАЗСЗөлөл (Д.БАТЖАРГАЛ)-д үүрэг болгох, 3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан ТАЗ-ийн "Журам батлах тухай" 2004 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 39 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцох тухай МУ-ын ТАЗ-ийн тогтоол гаргахаар тогтов.
4	Зэвсэгт хүчний Жанжин штаб болон түүний харъяа цэргийн анги, байгууллагын төрийн тусгай албан тушаалд анх орох иргэнээс мэргэшлийн шалгалт авах журам"-ын төслийн тухай	1."Зэвсэгт хүчний Жанжин штаб болон түүний харъяа цэргийн анги, байгууллагын төрийн тусгай албан тушаалд анх орох иргэнээс мэргэшлийн шалгалт авах журам"-ыг хавсралтаар батлах, 2.Энэхүү журмыг чанд мөрдөж ажиллахыг Зэвсэгт хүчний Жанжин штабын дэргэдэх ТАЗСЗөвлөл (Ц.БЯМБАЖАВ)-д үүрэг болгох,

		3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан ТАЗ-ийн “Журам батлах тухай” 2003 оны 9 дүгээр сарын 11-ний өдрийн 23 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцох тухай МУ-ын ТАЗ-ийн тогтоол гаргахаар тогтов.
5	Монгол Улсын Төрийн албаны зөвлөл байгуулагдсаны 15 жилийн ойд бэлтгэх, тэмдэглэх ажлыг зохион байгуулах ажлын төлөвлөгөөний тухай	1.МУ-ын ТАЗ байгуулагдсаны 15 жилийн ойд бэлтгэх, тэмдэглэх ажлыг зохион байгуулах ажлын төлөвлөгөөг дахин редакци хийж батлах, 2.ТАЗСЗ-үүдэд хандсан уриалга албан захидал хүргүүлэх, 3.Ой тэмдэглэх асуудлаар шийдвэр гаргах эрхийг Зөвлөлийн даргад олгож, Зөвлөлийн дарга Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороонд энэ асуудлаа танилцуулж, тодорхой шийдвэр гаргуулах талаар ажиллахыг чиглэл болгов.
6	Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагуудаас төрийн захиргааны зарим албан хаагчид төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв олгуулах талаар ирүүлсэн саналын тухай	1.Тэргүүн түшмэлийн зэрэг дэвийн: Ц.Бадрахад дөтгөөр зэрэг, Д.Зүмбэрэллхам, Д.Батбаяр нарт тэргүүн зэрэг тус тус олгохоор, 2.Эрхэлсэн түшмэлийн зэрэг дэвийн: Т.Энхтуяад гутгаар, Ш.Жаргалсайханд дөтгөөр, М.Алтангэрэлд тэргүүн, Д.Баатарсайханд гутгаар, С.Энхболдод дөтгөөр, С.Эрдэнэтуяад дөтгөөр, Д.Отгонбаатарт дөтгөөр, Ч.Мөнхдэлгэрт гутгаар, Б.Ганбатад гутгаар, Б.Хүрэнбаатарт дэд, Б.Ганболдод гутгаар, Т.Доржхандад гутгаар, Х.Пүрэвсүрэнд гутгаар, Б.Нямаад дөтгөөр, Ж.Ганбатад дөтгөөр, Б.Бат-жаргалд гутгаар, Б.Батбаярт дөтгөөр, Ц.Адъяа-хишигт дөтгөөр зэрэг тус тус олгохоор шийдвэрлэж, МУ-ын Засгийн газарт хүргүүлэхээр болов.
7	Нийслэлийн дүүргүүдэд Хүний нөөцийн удирдлагын талаар хийх үзлэгийн тухай	ТАЗ нийслэлийн ТАЗСЗ-тэй хамтарч нийслэлийн 9 дүүрэгт 2010 оны 02 дугаар сарын 4-5-ны өдрүүдэд хамтарсан шалгалт хийх нь зүйтэй гэж үзэв.
8	Төрийн албаны стандартын удирдлагын үзэл баримтлалын талаар хийж буй судалгааны ажлын тухай	Энэ асуудлыг хойшлуулав.
9	Бусад асуудал: Төрийн албаны Зөвлөлийн Ажлын албаны Хөдөлмөрийн дотоод журамд өөрчлөлт оруулах тухай	1.ТАЗ-ийн 2003 оны 11 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн Ажлын албаны Хөдөлмөрийн дотоод журам”-ын 72 дугаар зүйлийг дор дурдсанаар өөрчлөн найруулах: “72.Ажилтан энэ журмын 41 дүгээр зүйлд заасныг биелүүлээгүй, хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр дараалсан 2 ба түүнээс дээш удаа ямар нэг хугацаагаар ажил тасалсан болон энэхүү хөдөлмөрийн дотоод журмыг зөрчсөн нь ТАТХ-ийн 13.1.5-д заасан үүргээ биелүүлээгүй гэж үзэж, түүнд сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно” гэж өөрчлөх, 2.Хөдөлмөрийн дотоод журмын 68 дугаар зүйлийг хүчингүй болгосонд тооцох тухай МУ-ын ТАЗ-ийн тогтоол гаргахаар тогтов.